

ХЯТАДЫН УРАН ЗОХИОЛЫГ МОНГОЛ ХЭЛЭЭР  
ОРЧУУЛЖ ИРСЭН УЛАМЖЛАЛ

Жю Юэ (Jiu Yue)

**Abstract:** This article highlights the issues of the tradition of translating Chinese into Mongolian in certain level. In other words, Chinese literary works that have introduced Mongolia in doing so, it covers the period from the earliest times to the present, and evaluates the extent of its influence on Mongolian literature and culture.

**Key words:** *Chinese literature, Mongolian translation, translated literature, Mongolian-Chinese literary communication, Chinese novel*

## Эхлэл

Аль ч улс үндэстний утга зохиолын хөгжил, өв санд орчуулгын уран зохиол нь томоохон байр эзлэхийн сацуу утга зохиолын туурвил зүйн сэтгэлгээнд нь хурдасгуурын үүрэг гүйцэтгэж иржээ. Учир нь “орчуулга нь хүн төрөлхтний хоорондын харилцаа холбоог хөгжүүлэх, тухайн ард түмний соёл утга зохиолыг бусад оронд дэлгэрүүлэх, улс түмний утга зохиолыг баяжуулахад чухал үүрэг” (Билигсайхан, 2022: 318) гүйцэтгэдэг байна.

Монголын утга зохиолын хувьд эртнээс дорнын дахины улс үндэстний утга зохиолтой нягт холбоотой байж ирсэн нь, энэтхэг, төвөд, хятад хэлээс ихэвчлэн орчуулж ирсэн уламжлалтай холбоотой. Тухайлбал, “Бурхан шашин соёл”<sup>1</sup>-ын болон түүнтэй холбоо бүхий аман уламжлал<sup>2</sup>-ын арвин баялаг өвийг тэмдэглэсэн бүтээлийг санскрит, уйгур, төвөд хэлээс орчуулж байсан бол түүх, иргэний чиглэлийн уран сайхны зохиол бүтээлийг хятад, араб хэлээс орчуулсан монгол бичээч нарын гар дамжин дэлгэрсээр, улмаар монгол аж байдалд зохицсон монгол зохиол болон хувирч, хөгжин баяжсаар иржээ. Ийм үзэгдэл бараг ХХ зууны 20, 30-аад он хүртэл оршин байсныг Ц.Дамдинсүрэнгийн “Өчүүхэн дөрвөн үлгэр” (1929) зэрэг манай олон зохиолчдын бичсэн үлгэр өгүүллэгүүдээс харж болно.

Харин ХХ зууны 20, 30-аад оноос эхлэн, нийгмийн шинэ байгуулалд шилжин орсонтой холбоотойгоор Орос, Зөвлөлтийн уран зохиол, Өрнөдийн уран зохиолын зарим сонгодог бүтээл туурвилыг орос хэлээс орчуулах ажил эрчимжжээ. Үүнд, Л.Толстойн “Бодь сэтгэлтэй болохыг номлосон өгүүлэл”, Крыловын ёгт үлгэрүүд, Д.Фурмановын “Чапаев”, Н.Гоголийн “Байцаагч түшмэл”, С.Злобины “Салават баатар”, Ж.Боккачогийн “Декамерон”, Ж.Свифтийн “Гулливрийн аялан явсан түүх”, М.Розенфельдийн “Алмасын хавцал”, Д.Дефогийн “Робинзон

<sup>1</sup> Энэ бол 1629 онд бүрэн орчуулж дууссан, 1100 гаруй зохиол бүхий 108 боть “Ганжуур”, 1742-1749 оны хооронд орчуулж дуусган хэвлэсэн, 3400 гаруй зохиолыг багтаасан “Данжуур”-ыг хэлж буй байна.

<sup>2</sup> Аман уламжлал бүхий бүтээл гэдэг нь санскрит, төвөд хэлээс орчуулсан “Панчатантра”-ын үлгэрүүд, “Рамаяна”, “Рашааны дусал”, түүний тайлбарууд, “Зохист аялгууны толь”, түүний тайлбарууд, “Субашид”, түүний тайлбарууд “Шидэт хүүрийн үлгэр”, “Кэсэнэ хааны намтар”, “Гучин хоёр модон хүний үлгэр”, “Бурхны арван хоёр зохионгуй”, “Банзрагч”, “Алтангэрэл”, “Бодичарияаватара”, “Махагалын магтаал” зэрэг олон зохиолыг хэлж байна.

<sup>3</sup> Үүнд хятад хэлнээс орчуулсан “Ачлалт ном”, “Тансан лам баруун этгээдэд зорчсон тэмдэглэл”, “Сүн улсын хүйтэн уулын бичиг”, “Сулхарнайн тууж” ... тэргүүт олон зохиолыг хэлж болно.

Крузо”, Ж.Вернийн “Арван таван наст ахмад”, Уэлл Жемсийн “Үүлэн бор”, Э.Погийн “Алтан цох”, А.С.Пушкин, И.С.Тургенев, Салтыков-Щедрин, Н.Островский, Т.Шевченко, Г.Мопассан, Х.К.Андерсен зэрэг олон зохиолчийн шилдэг бүтээлийг орчуулж монгол уншигчдын хүртээл болгожээ.

Гадаадын утга соёлыг монгол хэлээр орчуулж, ард түмнээ соён гэгээрүүлж ирсэн эрт үеийн Чойжи-Одсэр, Шаравсэнгэ, Лувсанринчен, XVII зууны бандида Гунгаа-Одсэр, XVIII зууны Урадгүүш Билэгийн Далай (Шаравжамц), Жанжаа хутагт Ролбийдорж, Дайгүүш Агваандампил, Хөх хотын гүүш Цорж, Ойрадын Зая бандида Намхайжамц, Цахар гэвш Лувсанчүлтэм, орчин үеийн Д.Нацагдорж, Ц.Дамдинсүрэн, Б.Ринчен, Ж.Цэвээн, Х.Пэрлээ, Э.Оюун, Б.Гонгоржав, Ц.Цэдэнжав, Ч.Чимид, Ц.Хасбаатар, М.Цэдэндорж, П.Чойжил, С.Бадраа, Г.Амар, Г.Аким ... зэрэг нэрт орчуулагчдын хөдөлмөр зүтгэлээр үр дүнд монгол орчуулгын ажил тасралтгүй залгамж холбоотой явж ирж, улмаар энэхүү орчуулгын түүхэн хөгжлийн явцад монголчуудад “уран зохиолын зүйлийг орчуулах гурван өөр үндсэн арга боловсорч тогтжээ. Энэ гурван аргын нэг нь үсэгчлэн орчуулах арга, нөгөө нь утгачлан орчуулах арга, гурав дахь дуурайлган зохиох арга” (Хүрэлбаатар, 1995: 158) ажээ.

Тэгвэл өдгөө Монгол орноо төлөвшин тогтож буй ардчилсан нийгэм, олон тулгуурт оюун санааны үзэл баримтлал, үзэл бодлын эрх чөлөөт орчинд тулгуурласан орчуулгын зохиолын шинэ үзэл, хандлага буй болсон байна. Энэ нь юуны өмнө,

1. Монгол орчуулгын уран зохиол бүтээгч - орчуулагчдын цоо шинэ эгнээ бий болсонтой,
2. Уламжлал шинэчлэлийн бодлогыг хослуульж байгаатай
3. Дэлхийн соёлт хүн төрөлхтний бүтээсэн шилдэг өв уламжлалыг тухайн бүтээлийн эх хэлнээс нь орчуулж, ард түмэндээ танилцуулах, соён гэгээрүүллийн үйл ажил хийж байгаатай
4. Орчин үеийн менежмент, удирдлагын бүтэц тогтолцоо, орчуулгын үнэлэмж бүхий, уншигч олныхоо эрэлт хэрэгцээ, хүсэл сонирхол мэдрэмжийг нэн түрүүнээ чухалд тооцон авч үздэг, оюун сэтгэлгээний эрх чөлөөг дээдэлсэн хэвлэлийн газар [publishing]-ууд төлөвшин тогтож байгаатай холбоотой болно.

### **Хятадын уран зохиолыг монголд орчуулж ирсэн уламжлал, туршлага**

Монгол орчуулгын түүхээс үзэхэд хятад хэлнээс, их төлөв иргэний чиглэлийн, уран сайхны шинж нь давамгайлсан зохиол бүтээлийг орчуулж иржээ. Үүнд нэн түрүүнээ Юань гүрний үед модон бараар хэвлэсэн нангиад-монгол хавсарсан “Ачлалт ном” буюу “Тахимдуу бичиг”-ийг авч үзэх ёстой. Эл бүтээл БНХАУ-ын Бээжин хотын Хааны ордон музейн номын санд хадгалагдаж буй монгол бичгээрх нандин дурсгал болно.

Ачлалт ном нь НТӨ 200-аад оны үед зохиогдсон бөгөөд түүнийг орчуулсан, хэвлэсэн тухай мэдээ Хятадын түүхийн сурвалж бичгүүдэд байдаг ба тухайлбал, Юань улсын үед орчуулсан номын нэрийн жагсаалтад тэмдэглэгджээ. Уг номыг Болдтөмөр 1307 онд орчуулсан тухай мэдээ бий бөгөөд Ачлалт ном бол эцэг эхээ ачлахыг заан сургасан агуулгатай юм. Ачлалт номыг монголчууд удаа дараа орчуулж ирсэн нь энэ ном монголчуудад ихэд дэлгэрч байсныг харуулдаг. Мөн түүнчлэн эл бүтээлийг төрийг засах ёсны, монгол хэл бичиг сурахад сурах бичгийн зорилгоор хэрэглэж байсан гэдэг мэдээ баримт олдсоор байна. Юань улсын Буянт хаан (1285–1320)-ы үед хятад нийгэм соёл суртлын зохиолууд болох “Шүүмжлэл өгүүлэл”, “Ачлалт ном”, “Их суртахуй” зэргийг монгол хэлнээ орчуулуулж, монгол сайд нарт уншуулж судлуулж байсан байна. “Ачлалт ном”-ыг Монгол Улсын эрдэмтэн Х.Лувсанбалдан, монгол орчуулгын хэсгийг латин үсгээр галиглаж, товч оршил, үг, өгүүлбэр, утгын холбогдолтой 197 тайлбарыг, тайлбар тус бүр дотроо 2-6 зүйлтэйгээр хийж, үгсийн хэлхээ, дүгнэлт, эхийн гэрэл зургийн хамтаар хэвлүүлсэн (2015: 182) нь Монгол Улсын ШУА-ийн 1961 оны шилдэг

бүтээлээр шалгарч байсан түүхтэй ажээ.

XX зуунаас өмнө үед Монгол орноо уран бүтээл нь ихэд дэлгэрсэн, Хятадын утга зохиолын түүхэнд шинэ үеийг нээсэн гэгддэг зохиолч бол Пү сүнлин (1640-1715) билээ. Тэрээр 1000 орчим шүлэг найраг, 15 жүжиг, олон арван эсээ нийтлэл, өгүүлэл бодрол хийгээд Хятадын утга зохиолын хэвшмэл намтарчилсан түүх бичлэгийг халж, шинэтгэсэн хүүрнэл зохиол, өгүүллэгээрээ алдаршжээ. Түүний бичлэгээс эхлээд Хятадын уран зохиолд жинхэнэ уран сайхны дүр, уран санаа бүхий намтарчилсан түүх бус, цэвэр сэтгэлгээний үйл явдлууд өрнөх болсон гэдэг. “Пү сүн-лингийн зохиосон гэгдэх Эрт эдүгээгийн гайхамшиг сайхан үзэгдэл”<sup>4</sup> хэмээх судар” хэмээх роман Монголд нэлээд өргөн дэлгэр түгжээ. Энэ бүтээлийг 1959 онд академич Б.Ринчен эрхлэн нийтлүүлсэн<sup>5</sup> бөгөөд “Оршил” өгүүлэлдээ:

“Хэл зохиол судлах газраас энэхүү цуврал бичгийн арван нэг, арван хоёрдугаар боть болгон нийтэлж буй “Эрт эдүгээгийн гайхамшигт сайхан үзэгдэл” хэмээгчийг нангиад хэлнээс монгол дор хэд хэдэн удаа орчуулсан нь монгол уншигч нарын машид сонирхож байсны гэрч тэмдэг бөгөөд монгол үг найруулга сонин сайхан, яруу баялгийн чадлыг бүрэн хэрэглэжээ. Эдгээр үлгэрийн орчуулга нь бичгээс аман зохиолд нэвтэрч, монгол үлгэрч нар нөхвөр чимэг оруулан хэлэлцэхээр үл барам Монгол ард улсын тулгар төр байгуулагдсаны анх үеэс Улиастай, Алтанбулаг, Нийслэл хүрээний жүжгийн тайзнаа найруулан гаргаж байсан удаа ч буй болой. Үүнээ нийтэлсэн эл үлгэрийн эх бичиг нь Зая бандида Лувсанпэрэнлэйн номын санд байсан бөгөөд эдүгээ Монгол Улсын Нийтийн Номын Санд хадгалан буй болой. Эдүгээ түүнийг үржүүлэн хэвлэж, монгол уран зохиолын сан дахь олон улсын уран зохиолын монгол орчуулгыг үзэх судлах олон эрдэмтэн сэхээтний хүртээл болговой. Уг эх бичиг нь болгосон нангиад цаасан дээр сударчилсан гурван боть болгож бийрээр бичжээ. Газар орон, хүний нэрийг манж үсгээр бичсэнийг монгол галиг болгов. Өөр засвар оруулсангүй” гэж тэмдэглэжээ.

Тэгвэл “Эрт эдүгээгийн гайхамшигт сайхан үзэгдэл”-тэй орчуулгын талаасаа биш, туурвил зүйн асуудлаар холбогддог Монголын орчин үеийн уран зохиолын нэгэн баримт нь Д.Бодоогийн “Үзэмжит өгүүлэл” (1910) хэмээх тууж болно. Д.Бодоо “Үйлийн чанарыг өгүүлсэн үзэмжит өгүүлэл” туужаа бичихдээ “Эрт эдүгээгийн гайхамшигт сайхан үзэгдэл” романы 23-р бүлэг буюу “Зян Сингэ дахин алтан сувдан цамцтай учралдав” гэх бүлгийн өгүүлэмжийг уламжлан шинэчилж бичсэн, үйл хэрэг, газар орон, орчин ахуй, дүр зэргийг Монгол ахуй хөрсөнд шингээн баяжуулах замаар бичсэн байдаг.

Хятадын сонгодог уран зохиолыг орчуулсан монгол орчуулгын уламжлал, туршлагыг илтгэн харуулах нэгэн зохиол бол “Баруунш зорчсон тэмдэглэл буюу Тансан ламын үлгэр” [хят. 西遊記, анг. Journey to the West; 1592] роман билээ. Романыг Ү чэн-энь (1500-1582) хэмээх зохиолч, 629 онд Тан улсын Сюан Жүн (596-664) хувраг ганцаараа нууцаар Энэтхэг орон руу бурхны ном залахаар яваад 600 гаруй судар авч, 645 онд буцаж ирсэн тухай түүхэн үйл явдалд үндэслэн бичжээ. Эл зохиол нь Хятадын “Алдарт дөрвөн зохиол”-ын нэг юм. Зохиолч аман зохиол, ардын үлгэр домог, түүхэн үйл хэрэг явдлыг маш сайн мэддэг байсан нь аман уламжлалын эдгээр зүйлийг зохиолдоо ашигласнаас нь илэрхий харагддаг. “Баруун этгээдэд зорчсон тэмдэглэл” романыг дэлхийн олон хэлээр орчуулсан байдаг ба монгол хэлний орчуулгыг 1721 оны орчим Шинжаанд сууж байсан манж цэргийн нэгэн цахар жанжин Арна<sup>6</sup>

<sup>4</sup> Г.Галбаяр “Д.Бодоогийн “Үзэмжит өгүүлэл” зохиолын утга агуулга, дүр дүрслэлийн зарим онцлог” Mongolia: Area and culture studies the institute for mongolian studies. National University of Mongolia. Tom 3 (421). p.160, (157-170).

<sup>5</sup> Эрт эдүгээгийн гайхамшигт сайхан үзэгдэл хэмээх судар [Эрхэлсэн, оршил бичсэн Б.Ринчен. Corpus Scriptorum Mongolorum. Tom. XI. Дээд дэвтэр 1-246 (1-20-р бүлэг). Доод дэвтэр (21-40-р бүлэг) БНМАУ-ын Шинжлэх ухаан ба Дээд боловсролын хүрээлэнгийн хэвлэл. Улаанбаатар. 1959. 247-502 х.]

<sup>6</sup> Орчуулагч Арна (1660-1724). Чин улсын үеийн Шулуун шарын хошууны тэргүүн зэргийн жинхэнэ түшмэл

орчуулсан нь Монгол орноо үлэмж дэлгэрчээ.<sup>7</sup> Тэрээр 47 анги цохолбор ба оршлыг монгол бичгээр бичсэн ба монголчуудаас анх удаа хятад үндэстний туужсын зохиолд цохолт бичин, бинт зурж шүүмжлэх аргыг хэрэглэсэнээрээ онцлог билээ.

Үүнээс гадна хятад хэлнээс орчуулсан утга соёлын зүйлд XIX зууны дунд сүүл үеэс XX зууны эхэн үе хүртэл, ялангуяа суурин газар нутгаар нэлээд дэлгэрсэн хятад ший жүжгийн зохиол томоохон байр эзэлнэ. Учир нь Монголын театрын хөгжил, жүжгийн уран санд, тэр дундаа, XX зууны эхэн үеийн Монголын театр, жүжгийн ертөнцөд Хятадын алдартай роман зохиолыг жүжиг болгон зохиомжлон тоглох, хятад жүжгийн зохиол найруулан тоглох нь, нэлээн түгээмэл үзэгдлийн нэг байсан байна.

Энэ талаар эрдэмтэн зохиолч Э.Оюун: “Ардын хувьсгалын эхэнд жүжигчдийн нэг хэсэг нь нутаг буцаж, үлдсэн жүжигчид орон нутгуудаар цагаачлан үлдсэн хятадын хувьсгалчдын тусламжтайгаар урын санг хянан үзээд, хятадын ардчилсан, ардын шинж чанартай сонгодог жүжгүүдийг тоглох чиглэлийг баримтлах болжээ. Хоёр байранд хятадын хоёр хамтлаг ажиллаж байв. Нэг нь өмнө зүгийн аялгуун дээр, нөгөө нь хойд зүгийн аялгуун дээр тоглодог байжээ. Заримдаа эдгээр байранд Монголын сайн дурын уран сайхны дугуйлангууд тоглолт хийдэг байв. Тэдний урын санд “Тан овгийн хаадын түүх”-ээс “Дүенхэн баатар”, “Хун Лин-Ху баатар”-ын зарим бүлгийн болон “Гэсэрийн тууж”-ийн бүлгээс жүжиг болгон тоглодог байж” “...Жүжгийн зохиолыг бичдэггүй зөвхөн амаар жүжиг болгон ярилцаж, тайзан дээр үгийг шууд цээжээр зохиодог байсан учир, эдгээр жүжгүүдийн тухай, эдгээрийн агуулгын талаар тодорхой мэдэж чадсангүй.” “... 1922 онд Улаанбаатарын дугуйлангийнхан “Баруун этгээдэд зорчсон нь” хэмээх хятадын гүн ухааны романаар хийсэн “Тансан лам” гэдэг жүжиг тоглосон юм. Сониуч, зориг тэвчээртэй, идэвхтэй байдлыг дүрсэлсэн хаан сармагчинд тохиолдсон адал явдлыг харуулсан хэсгүүдтэй энэ жүжиг хятадын театрт өнөөг хүртэл тоглогдсоор байна. Жүжгийн гол утга нь Тансан лам хүмүүсийг элдэв өвчнөөс аврахын тулд ном олж ирэхээр Хятадаас баруун зүгт Энэтхэг рүү холын аянд гарна. Тэрээр замын хань болгон хүн, сармагчин, гахайг дагуулан явна. Тансан ламын шавь сармагчин их хөдөлгөөнтэй, юм бүхнийг сонирхдог, зорьсондоо хүрэхийн төлөө цөхрөлтгүй юунаас ч шантардаггүй, их ухаалаг аж. Эдгээр чанар сармагчинд бүгд байх учир багш нь түүнийг байнга номхруулан барьж байна. Тансан ламын хоёр дахь шавь гахай харин унтах дуртай, залхуу, авгайд дуртай. Энэ бол хүний өөдгүй, муу муухай чанарын илрэл байлаа. Шавь гахай багшдаа их гай тарина, янз бүрийн хорон муу санаат хүч, сайхан хүүхний дүрээр илэрдэг шажны дайснууд Тансан ламын замд саад тотгор учруула. Гэвч өөрийн ухаантай, зоригтой шавь сармагчингийн хүчинд бүх бэрхшээлийг даван туулж Бурхан багшид очин эмнэлгийн ном авна. Буцах замд нь гол гатлах үед номын хуудсууд задран унаж голд живнэ. Тансан лам тэдгээрийг аварч чадаагүй учир хүмүүс өнөөг хүртэл өвчнөөсөө ангижирч чадаагүй аж. Жүжиг тун сонирхолтой болж, гойд сайхан хувцас, нүүр будаг, циркийн янз бүрийн үзүүлбэр бүхий дайн тулааны хэсэг, төрөлх хэл дээрх дуу энэ бүхэн монгол үзэгчдэд ойлгомжтой байжээ”. “Олноо өргөгдсөний 12 дугаар оны 3-р сарын 12 буюу 1922 оны 5-р сарын 8-нд “Уриа” сонинд “Залуучуудын тоглосон жүжгийн тухай нэртэй жижигхэн өгүүлэл нийтлэгджээ. Түүнд: 1922 оны хавар Залуучуудын хурлын гишүүн Буяннэмэх, Насанбаг, Амгалан болон бусад хүмүүс төрөлх хэл дээрээ жүжиг тоглож, Монголын түүхийн хэсгээс, мөн Тан овгийн хаадын романы хэсгээс, Тансан ламын

бөгөөд туслагч жанжин, дотоод амбан зэрэг тушаал хариуцаж хилийн цэрэгт байжээ. Энх-Амгалангийн гучаад оны үеэр цэргийн зохих тушаалтай дайнд явж байсан мэдээнээс үзвэл, түүнийг энэ үед гучин настай байлаа гэж бодоход Арнын төрсөн цаг нь Эсэр засагчийн арваад он буюу Энх-Амгалангийн эхний онууд бололтой. Тэр бээр монгол, хятад, манж, төвөд бичиг нэвтэрхий мэддэг байжээ. Энх-Амгалангийн гучаад оны үеэс Ойрадын Галдан бошигт Халхтай тулалдаж байх үед Арна их Чин улсын хязгаарын цэрэгт зохих тушаал эрхэлж тэр байлдаанд оролцож явсан тухай “БНМАУ-ын түүх”-д тэмдэглэсэн байдаг.

<sup>7</sup> “Баруунш зорчсон тэмдэглэл буюу Тансан ламын үлгэр” [хят. 西遊記, англ. Journey to the West; 1592] романыг Өвөр Монголын Ардын хэвлэлийн хорооноос дөрвөн ботиор хэвлэсэн байна. Кирилл монгол бичигт 1996 онд МУБИС-ийн багш доктор С.Хөвсгөл, Д.Ариунцэцэг нар хөрвүүлж, “Тансан ламын баруун этгээдэд зорчсон түүх” нэрээр хэвлүүлжээ.

адал явдал зэргээс үзүүлсэнд үүний өмнө Монголд ийм жүжиг байгаагүй учир бүх цугларсан хүмүүст их таалагдсан тухай бичжээ”, “Наймаачин хотын хятад хүмүүсийн сууринд өөр бусад зугаа наадам, театрын үзүүлбэр байсан бөгөөд гол төлөв цагаан сараар болдог тэр баярт бүжиг, хиймэл морь бүхий уралдаан (бүжигчид бэлхүүсэндээ бэхэлдэг) болдог байж. Ийм театрчилсан жүжиг тоглох нь тийм ч амар зүйл байгаагүй бөгөөд хятад худалдаачид түүнд монгол хүүхнүүдийг хөлсөлдөг байжээ”, “Дугуйлангийнхны анхны жүжгүүд нь Хятад, Монголын холимог тоглолтын шинж чанартай байжээ. Тэд чадлын хэрээр найруулан тоглож байсан учир жүжгийг бүтээх зарчим, түүний хэлбэр тэдний хувьд асуудал биш байв. Гэвч жинхэнэ тайзан дээр тоглосон эдгээр анхны жүжгүүд залуу жүжигчдийг олон зүйлд сургасан бөгөөд хамгийн гол нь дүр бүтээх тухай, дүрд хувилах тухай ойлголт өгсөн ажээ”, “Түүний хамт хятадын сонгодог жүжгийг тоглосон явдал монгол үзэгчдийг хятадын утга зохиол, аман зохиол, хөрш орны оюуны амьдралтай монголчуудыг танилцуулж, ард түмний мэдлэгийг өргөжүүлэхэд тусалжээ. Ардын театрын анхны үйлчид хувьсгалын үзэл санааг сурталчлах явдалд хятадын ший янгууг ашиглажээ. Ший янгууны үндсийг хятадуудаас авсан бөгөөд гэхдээ зарим нэг дүрийг монгол маягтай болгожээ. Ший аялгууг ашиглах санаачлагыг эвлэлийн гишүүд гаргажээ. Анх санаачлагчид нь Амгалан, зохиолч Д.Нацагдорж, жүжигчин Насанбат зэрэг хүмүүс байжээ. Цагаан сарын өдрүүдэд тод содон хувцас өмсөн, модон хөл хийн, гартаа дэнлүү барьсан залуучууд энэхүү тоглолт үзүүлбэрт оролцдог байж. Эхний жил уг үзүүлбэрийн гол зорилго нь аль болох их мөнгө олж, хувьсгалын эхний хоёр гурван жилд асар олон байсан гуйлгачин нарт мөнгө өгдөг эвлэлийн байгууллагуудад туслах зорилготой байжээ. Гэвч сүүлдээ эдгээр үзүүлбэр залуучуудын эвлэлийн ухуулга сурталчилгааны ажлын хамгийн ойлгомжтой хэлбэрийн нэг болжээ” (Оюун, 2020: 329, 330, 331, 333, 334, 338) гэх мэтээр Монголын орчин цагийн жүжиг театрын хөгжилд хувь нэмэр болж, дэм тусаа үзүүлж, эергээр нөлөөлж байсан тухай авч үзжээ. Гэвч энэ үйл хэрэг удаан үргэлжилж чадаагүй байна.

МАХН-ын VII их хурлаас<sup>8</sup> Монголын урлаг, утга зохиол, соёл нийгмийн амьдралд реализмыг тууштай нэвтрүүлэх, ард олон хувьсгалч ёсоор оршин тогтнох ёстой, ингэхийн тулд үндэсний явцуу хүрээг даван гарч, Европын болон Оросын сонгодог өв, реалист уран бүтээлд хандах шаардлагатай байна. Тиймийн тул Хятад роман зохиол ший жүжиг гаргах явдлыг хориглолоо хэмээжээ. Энэ цагаас эхлэн бараг 1949 оныг хүртэл хятадын зохиол бүтээлийн орчуулгын ажил үндсэндээ зогсонги байдалтай болсон байна. Харин 1949 онд БНХАУ байгуулагдаж, БНМАУ - БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтож, үүнийг дагаад “ард түмэн хоорондын эв найрамдлыг эрхэмлэж, улс төр, утга соёлын гадаад харилцааг хөгжүүлэх эрмэлзэлтэй байсан төр засгийн бодлогын хүрээнд Монгол ард улс олон оронтой ах дүүгийн найрамдалт холбоог бэхжүүлэх дорвитой алхмууд хийж ирсний нэг нь” (Чимэдцэеэ, 2020: 79-89) хятад зохиолын орчуулга дахин сэргэсэн явдал болно.

Ийнхүү, МАХН-ын VII их хурал хуралдсан 1928 оноос хойш хойш 24 жилийн дараа, БНХАУ байгуулагдсаны 3 жилийн ойн үеэр Монгол-Хятад хоёр улсын засгийн газар хоорондын анхны хэлэлцээр болох “Монгол, Хятадын эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны хэлэлцээр”-т гарын үсэг зурснаар БНМАУ-д хятадын уран зохиолыг орчуулж, судлах ажил эрчимжсэн билээ. Монголын Засгийн газар хоёр ард түмний найрамдалт харилцааг чухалчилж, соёл уран зохиолын холбоог хөгжүүлэхэд ихээхэн ач холбогдол өгч байсан юм. Засгийн газрын дэмжлэгтэйгээр энэ жилүүдэд хоёр орны уран зохиолын холбоо харилцаанд онцгой анхаарч

<sup>8</sup> Д.Эрдэнэбат “Намын цэвэрлэгээ”, “МАХН-ын VII их хурал (1928)-ын шийдвэрээр 1929 оны зунаас 1930 оны эхэн хүртэл намын 18.618 гишүүдийг шалгаж, 5306 хүнийг намаас хөөжээ. Хөөгдөгсөд нь баруунтны үед намд шургалсан феодал, түшмэд, худалдаачин, панзчин, лам нар хэмээн цоллогдогсод байв. Эл шалгалтын дараа МАХН-ын гишүүдийн 99.3% нь ард ангийн төлөөлөгчид болжээ. Намын байгууллагыг шалган цэвэрлэх тухай зааварт ангийн биш этгээд, бослого хөдөлгөөнд оролцогчид, харгис дээд лам нартай сүлбэлдэгчид, албан тушаалаа хортойгоор ашиглагчид, ардын хэв заншил, сүсэг бишрэлийг доромжлогсод, улс олон нийтийн өмч хөрөнгийг идэж ашиглагчид зэрэг намын нэр алдрыг гутаагч этгээдүүдийг хөөж, эсэргүү хөдөлгөөнийг дарахад идэвхтэй оролцогчид, нам хувьсгалын үйл хэрэгт үнэнч хүмүүсийг элсүүлэх тухай дурджээ. <https://mongoltoli.mn/history/h/595>

байсан тул монгол хэлнээ хятадын зохиолч нарын бүтээлийг өргөнөөр орчуулах ажил өрнөж байв.

Хоёр улсын найрамдалт харилцаа байгуулагдсаны үр нөлөөгөөр, 1952 онд хятадын зохиолч Хэ Жин Жи, Дин И нарын зохиол “Буурал бүсгүй” жүжгийг орчуулан тавьсан нь, театр судлаач С.Дашдондогийн дурдсанчлан “Театрын урын сангийн бодлого нь орчуулгын жүжгүүд, ялангуяа Хятад жүжгийн зохиолыг орчуулан тавьсан нь театрын түүхэнд гарсан шинэчлэл” (1996: 172) болохын зэрэгцээ шинэ цагийн Монгол –Хятадын уран бүтээл, урлаг соёлын харилцаа холбооны түүхийн нэгэн үеийн эхлэл болсон ажээ. Жүжгийн орчуулгыг сэтгүүлч, орчуулагч Э.Түмэнжаргал хийсэн бол найруулагчаар Л.Ванган ажиллажээ. Улсын Хөгжимт Драмын Театрын тайзнаа тавигдсан “Буурал бүсгүй” жүжиг нь хятад эх зохиолынхоо өгүүлэмж, хэрэг явдал, зөрчлийн дагуу тавигджээ. Өөрөөр хэлбэл, эх зохиол, эх бүтээлээсээ аль нэгэн талаар, өөр ондоо болсон, зөрүүтэй болсон зүйл огтхон ч үгүй ажээ. Эл өгүүллийн 4-р хэсэгт агуулгын талаар тодорхойлсонтой яг адилхан юм. Тэгэхээр орчуулагч Э.Түмэнжаргалын хийсэн “Буурал бүсгүй” жүжгийн орчуулга нь, чухам эх зохиолынхоо утга санаа агуулгыг бүрэн төгс гаргасан сайн орчуулга болсон байна. Орчуулагч Б.Түмэнжаргал “Буурал бүсгүй” жүжгийг орчуулсан тухайгаа:

“-Би “Хэвлэл утга зохиол хянах ерөнхий газар” хуваарилагдаад төдий л удаагүй байлаа. Нэг өдөр Ч.Ойдов, Э.Оюун гуай хоёр хятадын “Буурал бүсгүй” жүжгийг орчуулаач гэж ятгадаг юм байна. Тэр үед И.Сталины 70 насны ой дөхөж ажилчин, албан хаагч бүр ямар нэг юм хийж бүтээх ёстой гэсэн хөдөлгөөн өрнөж байсан шиг санагдана. Нөгөөтээгүүр урьд нь би жижиг ном орчуулснаа гаргаж амжаагүй бас “Буурал бүсгүй” номыг уншчихсан. Энэ зохиолын тухай багагүй мэдээлэлтэй байсан. Хуучин нийгэм хүнийг буг болгодог гэх юм уу, “Буурал бүсгүй” жүжиг хятадын хөгжимт драмын шинэ үеийг нээсэн гэх юм уу. Энэ явдал Хятадын хойд зүгийн нутагт болсон үнэн түүх гэсэн ойлголт авсан байлаа. Залуу ч байж, зоригтой ч байж, оролдоод үзье гэж бодоод зөвшөөрчихлөө. Гэтэл энэ маань хөгжимт драмын жүжиг болохоор ярианы хэл голлосон бас дууны үг, шүлэглэлт хэсэг ихтэй юм. Ямар ч гэсэн орчуулж дуусгалаа. Шүлгийн хайрцаглал, найруулга талаас нь их сургуулийн нэг ангийн найз яруу найрагч Д.Тарваад үзүүлж, цэгцлээд, театрт шилжүүлээ. Театрт аваад таг чиг болчихлоо. Хоёр ч жил өнгөрсөн байх. Ингээд 1952 онд нөгөө жүжгийг маань тавих болсон аж. Театрын найруулагч нэрт зохиолч Л.Ванган, театрын сөөнгөдүү Чойжамц, тэр орчуулгаа дахин хянаж үзэхгүй юу гэж. Би завгүйгээ хэлж, түүгээрээ аргалж үзээч гэж хариу мэдэгдлээ. Гэтэл тэд тун сайхан болгож, тайзан дээр тавьсан л даа” (Цэндмаа, 2009: 10-11).

хэмээн дурссан байна. Найруулагч Л.Ванганы тавилтын шийдэл нь 5 бүлэг 15 үзэгдлийг, 3 бүлэг 13 үзэгдэл болгосон ч гэсэн, эл бүтээлийн агуулгыг бүрэн гүйцэд илэрхийлж чадсан юм. Энэ бол, “Буурал бүсгүй” жүжгийн орон зай, цаг хугацаа, эх зохиолд дүрсэлсэн нийгмийн орчин, драмын зөрчил тэмцлийн мөн чанарыг зөвөөр үзүүлэхэд чиглэгдсэн байсныг харуулж байгаа юм. Тийм ч учраас жүжиг, оройн 19.00 цагт эхэлж, 6 цагийн турш үргэлжилж, шөнийн 01.00 цагт дуусахад, үзэгчид огтхон ч залхаж, уйдсан шинжгүй, идэвхтэй, сонирхолтой, эрчимтэй хэвээр байдаг байжээ. Театр судлаач С.Дашдондогийн “Театрын урын сангийн бодлого нь орчуулгын жүжгүүд, ялангуяа Хятад жүжгийн зохиолыг орчуулан тавьсан нь театрын түүхэнд гарсан шинэчлэл” (1996: 172) хэмээн онцлон тэмдэглэсэн нь чухамдаа Л.Ванганы найруулгыг үнэлсэн хэрэг байжээ. Өөрөөр хэлбэл бүхэл бүтэн 6 цагийн турш, тайзан дээрх үзүүлбэрийн уур амьсгал, орчин, орон зай, цаг хугацаагаар үзэгчдийг аялуулна гэдэг хамгийн оновчтой, төгс төгөлдөр зохиомж, өгүүлэмжийн тогтолцоо бүрдэж байж гэмээ нь бүтэх зүйл билээ. Ийм шийдэл, туршлагыг найруулагч Л.Ванган бүтээн бий болгож чадсан байна.

Энэ шинэ ажлын гараатай зэрэгцэн хятадын орчин үеийн уран зохиолын нэрт төлөөлөгч Лү шюний “Галзуу хүний өдрийн тэмдэглэл”, “А Кьюгийн үнэн түүх”, Мао Дүний “Үнэгэн

харанхуйд”, Гө Мөрөгийн “Шанхайн өглөө”, Ба Жингийн “Тэр бүл”, Жоу Ли Богийн “Догшин салхи, ширүүн бороо” зэрэг олон ном орчуулсан байна. 1959 онд манай орчуулагчид дорно дахины үгийн урлагийн гоо сайхан, түүний арга барил, сэтгэлгээг уншигч олондоо танилцуулахыг зорьж байсан нь хятадын эртний сонгодог шүлэгч Ли Бай-гийн яруу найргийг орчуулсан байдлаас харагдана. Энэ тухайгаа Б.Явуухулан, Ч.Чимэд нар “... Бид Ли Байгийн шүлгийг орос хэлээс дам орчуулсан болохоор учир дутагдалтай нь мэдээж юм. Хятадаас оросоор, оросоос монгол хэлэнд дамжсаныг зүйрлэвэл хятад торгыг хоёр дахин усанд базан гаргасан лугаа адил. Дундад азийн нэгэн яруу найрагч орчуулгын шүлгийг “шилэн бүрхүүл доорх үнэрт цэцэг” гэж зүйрлэсэн байдаг. Тийм учраас Ли Байгийн шүлгийн тансаг үнэр бидний орчуулгын шилэн бүрхүүлийг нэвт ханхлах эсэхэд би эргэлзэнэ...” гэж тэмдэглэж байжээ.

Энд нэг зүйлийг онцлон тэмдэглэхэд, эрдэм шинжилгээний судалгааны ажлын чиглэлээр хятадын алдарт түүх сурвалжийн бүтээлээс дээжлэн нийтэлсээр ирсэн нь сайшаалтай. Үүнд “Фа Сяи жуулчны тэмдэглэл”, “Хэ ван Юанийн бичиг гэдэг тууж”<sup>10</sup> зэргийг дурдаж болно. “Фа Сяи жуулчны тэмдэглэл”-ийг академич Б.Ринчен эрхлэн нийтлүүлсэн байна. Энэ бүтээлийн гол онцлог нь оргүй алдагдсан гэж үздэг байсан, өнгөрсөн зууны тэргүүн хагаст Дорж Банзаровын франц хэлнээс монгол хэлнээ орчуулсан, V зууны үеийн Фа сиан гэдэг жуулчны Энэтхэг аялан орсон тухайн тэмдэглэл бичиг болно. Тэр орчуулгын эхийн гар хуулбар дамжиж ирснийг энэ цувралд хэвлэжээ. “Хэ ван Юанийн бичиг гэдэг тууж” нь урьд эртний нэгэн түүхт явдлаас үндэслэсэн 4 бүлэгтэй, Эртний Хүн улс, тэр үед байсан Хятадын Хан улсын нэг түүхээс сэдэвлэсэн тууж ажээ.

1990-ээд оноос эхлэн хоёр орны нийгэм эдийн засаг, соёлын харилцаа дахин сэргэн өргөжсөн цаг үеэс хойш хятад зохиолын монгол хэлний орчуулга улам нэмэгдсээр, 2020 иод он хүртлэх сүүлийн 20 гаруй жилд олон арван шилдэг, роман тууж, шүлэг яруу найргийн орчуулгаар түгэн дэлгэрсээр байна. Үүнд Күнз (НТӨ 551-479)-ийн сургаал зохиол, Тан улсын яруу найрагч Дү фү (712-770)-гийн шүлэг зохиол, Алтан бумбан дахь лишийн цэцэг [хят. 金瓶梅, англ. The Golden Lotus; 1610], “Шүй хүгийн үлгэр” буюу “Сүн улсын хүйтэн уулын бичиг” [англ. water margin; 1340], “Улаан асрын зүүд” болон одоо үеийн хятадын шилдэг зохиолч, Нобелийн шагналт Мо ян (1955)-ы роман, туужууд, Зян Руны “Чонон сүлд”, Хятад, Тайваны телевизийн драмын бүтээлүүд зэргийг дурдаж болно.

Күнз (НТӨ 551-479) бол Хятадын алдарт гүн ухаантан билээ. “Түүнийг төрөх үед эцэг Хэ овогт нь хошууны захирагч байжээ. Күнз гурван насандаа эцгээсээ, 17-тойдоо эхээсээ өнчирсөн байна. Ийнхүү 10 хүүхэдтэй айлыг үүрч явах болжээ. 19 насандаа эхнэр авсан гэж түүхэд тэмдэглэстэй байдаг. Тэрбээр өндөр нуруутай 191 см, тухайн цагийн нэгэн түшмэлийн бичсэнээр бол, луу мэт толгойтой, адуу шиг хүзүүтэй, хүдэр бадир хүн байжээ. Түүний жинхэнэ нэр нь Күн Цю боловч шүтэн бишрэгчид нь Күн Фү Цзы буюу эрхэм багш Күн гэж нэрлэжээ. Түүний суртал бол маш нарийн бодож боловсруулсан ёс зүйн хууль юм. Күнз амьдралдаа дөрвөн зүйлээс түдгэлзэж явсан гэдэг” (Аюурзана, 2004: 35). Күнз зөвхөн соён гэгээрүүлэгч, их сэтгэгч байсангүй. Ханлиг улсуудаар хэрэн хэсэж, өтөл насандаа утга зохиол, түүх, гүн ухаан, улс төр, засаглал, нийгэм, ёс суртал зэргийг тал бүрээс нь гүнзгий шинжлэн үзэж үзэл сургаалаа айлдан номлосноор Күнзийн сургаалыг үндэслэн буй болгожээ. Күнз хийгээд түүний шавь нарын эмхэтгэж туурвисан алдарт “Дөрвөн ном, таван бичиг” бүхэлдээ Күнзийн сурталын үндэс болдог. Күнзийн сургаал Хятадын засаг захиргааны албан ёсны гүн ухаан байсан төдийгүй тус улсын ард иргэдийн ертөнцийг үзэх үзэл болж тэдний амьдралд гүн нөлөө үзүүлсээр ирсэн, өдгөө ч уг чанар, үнэ цэнээ алдаагүй билээ. Түүний “Шүүмжлэлт өгүүлэл”-ийг М.Чимэдцэеэ 2005 онд, “Ачлалт ном”, “Шударга ном” зохиолыг нь Ч.Нарантуяа 2004 онд орчуулжээ.

<sup>9</sup> *Фа сиан жуулчны тэмдэглэл*. 1970. Corpus Scriptorum Mongolorum. Т. V, fasc.5. Улаанбаатар.

<sup>10</sup> *Хэ ван юаны бичиг гэдэг тууж*. 1969. Corpus Scriptorum Mongolorum. Т. XVI, fasc. 1. Улаанбаатар.

“Ши жин” буюу “Шүлэглэлт ном” [анг. classic of poetry; НТӨ XI-VI] бол Хятадын алдарт сонгодог дөрвөн номын нэг. Энэ түүвэрт янз бүрийн үеийн Хятадын өөр өөр нутаг орны ардын аман зохиолыг түүвэрлэн оруулсан байдаг. Нийт 305 шүлэгтэй бөгөөд эдгээр дуу шүлэг нь баруун Жоу улсын (НТӨ 1122-770) эхэн үеэс “Хавар намар”-ын улсын (772-481) төгсгөл үе хүртэлх хугацаанд зохиогджээ. “Ши жин” нь Улсын суртахуун, бага магтаал, их магтаал, сүлд дуу гэсэн дөрвөн бүлгээс бүтдэг байна.

Тан улсын яруу найрагч Дү Фү (712-770) залуу насаа олон газраар аялан явж ард түмний бодит амьдрал ахуйг ажиглан байгалийн сайхныг бахдан биширч явсан нь хожмын уран бүтээлд нь нөлөөлжээ. Тэрбээр 744 онд алдарт яруу найрагч Ли Бай, Гао Ши нартай дайралдан нөхөрлөж, Линьци гэдэг газар зуныг хамт өнгөрөөсөн гэдэг. Дү Фү тухайн цагийнхаа Хятадын ард түмний зовлон гунигийг яруу найрагт дүрслэн үзүүлснээрээ уран зохиолын түүхэнд мөнхөрсөн ба “Сартай шөнө” тэргүүтэй шүлгүүдийг нь Я.Ганбаатар монгол хэлэнд орчуулсан байна.

“Жин Пин Мэй бичиг” буюу “Алтан бумбан дахь лишийн цэцэг” хэмээх роман нь “Эротик утга зохиолын оргил” гэж алдаршжээ. Монгол улс болон Өвөр монголын номын санд хэд хэдэн орчуулгын хувилбараар хадгалагдаж байна. Өдгөө дэлхийн бүх томоохон хэлээр гарсан энэ романд Симын Цин хэмээх баян өрхийн тэргүүн эрийн амьдралыг хуял тачаал, ужид цэнгэлийн түүх маягаар өгүүлсэн байна. Эл зохиолыг барууны орнуудад садар самууныг сурталчилсан зохиол хэмээн олон жилийн турш хорин цагдаж байсан нь улам л алдаршуулсан ажээ. Эл зохиолыг орчуулагч Б.Дашцэрэн монгол хэлэнд орчуулжээ.

Тэгвэл 120 бүлгээр уламжлагдан ирсэн “Улаан асрын зүүд” роман романыг бичиг соёлын нэрт зүтгэлтэн Хасбуу 1847 онд 40 бүлэг болгож, хураангуйлан монголчлоод “Шинэ орчуулсан “Хун лөү мэн бичиг” хэмээн нэрийдээд монгол оронд гар бичмэлээр дэлгэрүүлжээ. Тэрбээр бүлэг бүрд нь цохолбор бичиж, бас оршил, унших арга хийгээд бүгдийн хуулал зэрэг дөчин гурван анги өгүүлэл бичиж, утга зохиолын амьдралыг тусгах үндсэн онцлогийн тухай, утга зохиолын доторх хүмүүсийн дүр хэрхэн бүтээх тухай, зохиолын үйл явдал, сэдэв, санаа, хэл хэллэгийн тухай маш чухал онолуудыг дурдан гаргажээ. Тэгвэл 1976 онд Д.Сайнбаяр, Чандмань нар бүрэн орчуулж, зургаан ботиор хэвлүүлсэн байна. Хуучин товчилсон орчуулгыг Өвөр Монголд дөрвөн ботиор хэвлэсэн байдаг. 2009 онд энэ товч сонгодог орчуулгыг кирилл бичигт буулган хэвлүүлжээ.

Нобелийн шагналт зохиолч Мо ян (1955)-ы хувьд хятадын уран зохиол дахь шидэт реализмын үзэл баримтлалыг илэрхийлснээрээ Маркесын шидэт реализм, Фолкнерын домог зүй, далд бэлгэдлүүдтэй холбоотой ажээ. Түүний “Дарсны орон” романыг 2014 онд, “Эргэлт” намтарчилсан туужийг нь 2016 онд Монсудар хэвлэлийн газрын орчуулагч Б.Гэрэл монгол хэлээр орчуулсан байна. Мөн түүнчлэн түүний “Амьдралын хүрдэнд зүдэгсэд” романыг 2019 онд, “Мэлхий” романыг нь 2020 онд орчуулсан байна. Үүнээс гадна Юн чаны “Зэрлэг хун: Хятадын гурван охин” (роман), Май зиагийн “Харанхуйд” (роман) монголын уншигчдын хүртээл болов.

Энэ бүхнээс дүгнэн үзвэл, Хятадын зохиолын монгол хэлний орчуулга нь баялаг өв уламжлал, орчуулгын туршлагыг бүтээж чаджээ. Дэлхийд Хятадын сонгодог зохиол, сонгодог роман хэмээн алдаршсан гол бүтээлүүдийг монгол орчуулагч нар эх хэлээрээ орчуулж, үндэсний орчуулгын зохиолын өв сангаа баяжуулсаар байна. Нөгөө талаар хятад хэлний мэргэжлийн орчуулагчдын шинэ эгнээ бий болж, энэ үйл хэрэгт Ц.Базаррагчаа, Ч.Сүрэнжав, М.Чимэдцэеэ, Д.Болдбаатар, Г.Цогзолмаа, Ш.Эгшиг, В.Батмаа, Б.Анандгэрэл тэргүүт олон орчуулагч манлайлж байгаа бол, “Непко”, “Тагтаа” зэрэг хэвлэлийн газрын хамт олон санаачилгатай ажиллаж байна. Хоёр орны соёлын байгууллага болон орчуулагчдын санаачилгаар “Монгол Хятад хэлний орчуулгын анхдугаар чуулга уулзалт” – “Монгол Хятад хэлний орчуулагчдын холбоо”-ны нээлтийн ёслол 2015 онд Улаанбаатар хотноо болсон бол, 2019 онд “Монголын Хятад судлал болон Хятад, Монголын соёлын сонгодог бүтээлийг харилцан орчуулах” форум,



“Азийн сонгодог бүтээлийг харилцан орчуулах төлөвлөгөө” эрдэм шинжилгээний хурлыг Бээжин хотноо, Монгол, Хятадын орчуулагчдын уулзалтыг Хөх хотноо зохион байгуулав. Эдгээр хамтын ажиллагааны үр дүнд Хятадын 25 телевизийн олон ангит кино МҮОНТ-ээр гарсан бол, “Нэпко” хэвлэлийн газар Хятадын сонгодог зохиол бүтээлүүдээс бүрдсэн 10 номыг уншигчдынхаа гар дээр өргөн барьсан нь хятад уран зохиолын монгол хэлний орчуулгын амжилтын нэг мөн.

### Ном зүй

- Аюурзана Г.** *2x2=6 буюу суут жаран сэтгэгч.* Улаанбаатар, 2004.
- Байгалсайхан С (ред.).** 2022. *Монгол утга зохиолын нэвтэрхий толь-II боть.* ШУА, Хэл зохиолын хүрээлэн. Улаанбаатар.
- Болормаа Д.** 2021. *Дэмчигдорж “Юань улсын судар”-г хятад хэлнээс орчуулав.* Хэл зохиолын хүрээлэн 100 жил, 100 үйл явдал, 100 зураг, 100 эрдэмтэн. Улаанбаатар.
- Галбаяр Г. Д.** *Бодоогийн “Үзэмжит өгүүлэл” зохиолын утга агуулга, дүр дүрслэлийн зарим онцлог,* Mongolia: Area and culture studies the institute for Mongolian studies. National University of Mongolia. Tom 3 (421). (157-170).
- Дашдондог С.** 1996. *Жаран жилийн шаштир I боть,* Номыг эрхэлсэн А.Таяа, Х.Зандраабайдий, Улаанбаатар.
- Лувсанбалдан Х.** 1961 (2015). *Ачлалт номын тухай.* Монголын судлал ХЗХ ЭШБ. Улаанбаатар. Том. III. fasc. 12. IV+150+37х: -2 дахь хэвлэл. Улаанбаатар.
- Монголчуудын театрын ардын урлагийн үндсүүд.* 2020. Эрдэмтэн зохиолч Э.Оюун: Бүтээлийн цоморлог II. Эрхлэн, эмхэтгэсэн. Ууганбаатар Ж. Улаанбаатар.
- Фа сиан жуулчны тэмдэглэл.* 1970. Corpus Scriptorum Mongolorum. T. V, fasc.5. Улаанбаатар.
- Хүрэлбаатар Л.** 1995. *Монгол орчуулгын товчоон.* Улаанбаатар.
- Хэ ван юаны бичиг гэдэг тууж.* 1969. Corpus Scriptorum Mongolorum. T. XVI, fasc. 1. Улаанбаатар.
- Чимэдцэеэ М, Нар.** 2020. *Орчуулгын уран зохиол хамрах хүрээ, тойм, ХХ зуун монголын утга соёлын өв.* Улаанбаатар.
- Цэдмаа Д, Дүүриймаа Э.** 2009. *Төрийн шагналт уран бүтээлч I.* Улаанбаатар.
- Эрт эдүгээгийн гайхамшиг сайхан үзэгдэл хэмээх судар.* 1959. Эрхэлсэн, оршил бичсэн Б.Ринчен. Corpus Scriptorum Mongolorum. Том. XI. Дээд дэвтэр 1-246 (1-20-р бүлэг). Доод дэвтэр (21-40-р бүлэг) БНМАУ-ын Шинжлэх ухаан ба Дээд боловсролын хүрээлэнгийн хэвлэл. Улаанбаатар. х. 47-502.